



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар

5/80

Улаанбаатар хот

### П.Мөнхбаатарт сахилгын шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7, 37.1.12, 48 дугаар зүйлийн 48.1.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.3, 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 4.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын 5.6.5, 5.6.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Пионерийн Мөнхбаатар нь албан тушаалын тодорхойлолтод заасан хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх, улсын бүртгэгчийг удирдлага, арга зүйгээр хангах, хяналт тавих чиг үүргийг хангалтгүй биелүүлсэн, хуулиар хүлээсэн албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан нь иргэний мэдээлэл, түүний гаргасан тайлбараар тогтоогдож байх тул түүнд 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг П.Мөнхбаатарт үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571000223